



БАЯНХОНГОР АЙМАГ  
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/47

Хөхбүрд

“Хүүхдийн тоглоомын талбайн засварын  
ажил хүлээлцэх ажлын хэсэг  
томилох тухай

Монгол Улсын Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 11 дүгээр зүйлийн 11.1 заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн “Хүүхдийн тоглоом”-ын талбайн засвар, тохижилтын ажлын гүйцэтгэлийн ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: М.Жавзансүрэн (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: Д.Отгонцэцэг (Төсөв төрийн сангийн мэргэжилтэн)

Ө.Ариунзаяа (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Э.Мөнх-Эрдэнэ (Сан хариуцсан нягтлан бодогч)

П.Батцэцэг (Нярав )

2.Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд “Хүүхдийн тоглоом”-ын талбайн засвар, тохижилтын ажлыг нэг бүрчлэн хариуцлагатай чанартай хийгдсэн эсэхэд шалгалт хийж ажлын талаарх шаардлагатай тэмдэглэл, фото зургийг илтгэх хуудасны хамт гүйцэтгэгч компаниар албажуулж, тайланд хавсаргахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Г.Ганцоож)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ж.ХАТАНБААТАР



642301063